



Тэмдэглэл

Бүх бодлогын хувьд:

- Бодлого бүрийн хувьд бодлогын хязгаарлалтыг (хугацааны хязгаарлалт болон санах ойн хязгаарлалт) CMS системийн "Overview" цэсээс харах боломжтой.
- Бодлого бүрийн хувьд хавсралт файл, жишээ grader жишээ хэрэгжүүлэлт, комфайлдах болон ажиллуулах скрипт, жишээ тест зэргийг CMS системээс татаж авч болно.
- Бүх бодлогод 50 хүртэлх удаа бодолтоо илгээж болох ба бодолт бүрийн хувьд зөвхөн нэг файл сонгож илгээнэ.
- Програмыг жишээ grader ашиглан турших явцад бодлогын хязгаарлалтад багтсан өгөгдөл оруулах шаардлагатай. Эс тэгвээс ямар алдаа гарахыг тааварлах аргагүй.
- Жишээ grader-ийн оролт дээр дараалсан хоёр өгөгдлийг нэг мөрөнд өгөхдөө дунд нь нэг ширхэг хоосон зай, дараалсан мөрөнд өгөх бол нэг ширхэг хоосон мөр ашиглахыг зөвлөж байна.
- Хувийн компьютер дээр өөрийн бичсэн кодоо тестлэхдээ хавсралт доторх скриптүүдийг ашиглахыг санал болгож байна. Үгүй бол компайлдахдаа `-std=gnu++17` тохиргоог ашиглаарай.
- Хэрэв та CMS системд өөрийн кодоо илгээж чадахгүй байвал `ioisubmit` командыг ашиглаж болно. Энэ командыг ашиглаж хадгалсан кодыг тэмцээний дараа шалгах болно. Энэ командыг ашиглахдаа:
 - Терминал дээр `ioisubmit <task_shortname> <source_file>` командыг өөрийн код байгаа хавтсан дотроосоо ажиллуулаарай.
 - Ажиллуулмагцаа хорооны гишүүнд хэлж энэ командын гаралтын зургийг авахыг хүсээрэй. Хэрэв аваагүй бол дахин шалгахгүй болохыг анхаарна уу.
 - Хэрэв та онлайнаар оролцож байгаа бол хянагчдаа хандаж болно. Тэр бидэнд илгээх болно.

Нэмэлт мэдээлэл

Бодлогын өгүүлбэр дээр ашигласан `void`, `int`, `int64`, `int[]` (array), and `int[][]` (array of array) гэсэн ерөнхий төрлийн загварыг ашигласан. Энэ нь C++ хэлэнд хэрэгжүүлэхэд дараах төрөлтэй тохирно.

void	int	int64	int[]
void	int	long long	std::vector<int>

int[][]	length of array a
std::vector<std::vector<int>>	a.size()

C++ хэлний <variant> толгой файлд std::variant төрөл тодорхойлогдсон байдаг. std::variant<bool, std::vector<int>> энэ нь bool эсвэл std::vector<int> төрлийн утгын аль нэгийг авч болно.

Дор үзүүлсэн жишээ кодонд std::variant төрлийн утга буцаах функцийг жишээг харууллаа.

```
std::variant<bool, std::vector<int>> foo(int N) {
    return N % 2 == 0;
}
std::variant<bool, std::vector<int>> goo(int N) {
    return std::vector<int>(N, 0);
}
std::variant<bool, std::vector<int>> hoo(int N) {
    if (N % 2 == 0) {
        return false;
    }
    return std::vector<int>(N, 0);
}
```